



УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗАР

**МОНГОЛБАНКНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТҮҮНД ХОЛБОГДОХ АУДИТЫН
САНАЛ, ДҮГНЭЛТ БОЛОН ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН САНАЛ, ЗӨВЛӨМЖИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ 2022 ОНЫ ТАЙЛАНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭНИЙ
ТАНИЛЦУУЛГА**

Улаанбаатар хот
2023 он

АГУУЛГА

Хуудасны дугаар

УДИРТГАЛ	3
НЭГ.МОНГОЛБАНКНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТҮҮНД ХОЛБОГДОХ АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТИЙН ТАЛААР	4-8
ХОЁР.МОНГОЛБАНКНЫ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ, ТҮҮНИЙ САНАЛ, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР	8-12
ГУРАВ.ТӨВ БАНК /МОНГОЛБАНК/-НЫ ТУХАЙ ХУУЛЬД ЗААСАН МОНГОЛБАНКНЫ ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ	12-20
ДӨРӨВ.ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	20-21
Хүснэгт 1. Монголбанкны 2018-2022 оны санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт	
Хүснэгт 2. Монголбанкны 2018-2022 оны санхүүгийн тайлангийн үндсэн үзүүлэлт	
Хүснэгт 3. Монголбанкны 2021-2022 оны хөрөнгийн үзүүлэлтийн харьцуулалт	
Хүснэгт 4. Монголбанкны 2021-2022 оны нийт өр төлбөрийн харьцуулалт	
Хүснэгт 5. Монголбанкны 2021-2022 оны нийт өөрийн хөрөнгийн харьцуулалт	
Хүснэгт 6. Монголбанкны 2018-2022 оны орлого, үр дүнгийн болон бусад орлогын тайлан	
Хүснэгт 7. Монголбанкны 2019-2022 оны үйл ажиллагааны бусад орлого, захиргааны ба үйл ажиллагааны бусад зардлын харьцуулалт	
Хүснэгт 8. Хяналтын зөвлөлийн дарга, гишүүдийн бүрэн эрхийн хугацааны талаарх мэдээлэл	
Хүснэгт 9. УИХТГ-аас Хяналтын зөвлөлөөс Монголбанканд хүргүүлсэн санал, зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлсэн байдал	
Хүснэгт 10. Хяналтын зөвлөлөөс Монголбанканд хүргүүлсэн санал, зөвлөмжөөс хэрэгжилт хангалтгүй санал, зөвлөмжийн жагсаалт	
Хүснэгт 11. Хяналтын зөвлөлөөс Монголбанкны аудитлагдсан тайланд есгөн санал, зөвлөмжийн талаарх мэдээлэл	
Хүснэгт 12. 2022 оны жилийн эцсийн байдлаарх гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний хэмжээ	
Зураг 1. Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ	
Зураг 2. Гадаад валютын улсын нөөц	

УДИРТГАЛ

Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсэгт “Монголбанк санхүүгийн тайлангаа аудитын санал, дүгнэлт болон Хяналтын зөвлөлийн санал, зөвлөмжийн хамт жил бүр Улсын Их Хуралд танилцуулна.” гэж, мөн хуулийн 27¹ дүгээр зүйлийн 27¹.9.4 дэх заалтад Хяналтын зөвлөл нь “Монголбанк энэ хуулийн 30 дугаар зүйлд заасны дагуу Улсын Их Хуралд тайлан, танилцуулга хүргүүлэх үед өөрийн үйл ажиллагааны тайланг хүргүүлж байх.” гэж тус тус заасны дагуу Эдийн засгийн байнгын хороонд:

- 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдөр “Монголбанкны 2022 оны тайлан”;
- Монголбанкны Хяналтын зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 04 дүгээр албан бичгээр “Монголбанкны Хяналтын зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны тайлан, холбогдох санал, дүгнэлт, мэдээлэл”-г тус тус ирүүлсэн байна.

Улсын Их Хурлын Тамгын газраас Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.3 дахь хэсэгт тус тус заасны дагуу дээрх тайлангуудад шинжилгээ хийсэн болно.

Тайланд шинжилгээ хийхдээ Төв банк /Монголбанк/-ны тухай хууль, Монголбанкны Хяналтын зөвлөлийн ажиллах журам, Монголбанкны 2022 оны тайлан, Монголбанкны Хяналтын зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны тайлан, холбогдох санал, дүгнэлт, мэдээлэл зэрэгт тулгуурлан баримт бичгийн болон статистик шинжилгээний арга зүйг ашиглалаа.

Тайланд шинжилгээ хийх хүрээг тогтоохдоо Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.4 дэх заалтын дагуу дараах агуулгын хүрээнд шинжилгээ хийж, танилцуулга бэлтгэлээ. Үүнд:

- Монголбанкны санхүүгийн тайлан, түүнд холбогдох аудитын санал, дүгнэлтийн талаар;
- Монголбанкны Хяналтын зөвлөл, түүний санал, зөвлөмжийн хэрэгжилтийн талаар;

Мөн Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд заасан Монголбанкны чиг үүргийн хэрэгжилтийн талаарх товч мэдээлэл бэлтгэлээ.

НЭГ.МОНГОЛБАНКНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТҮҮНД ХОЛБОГДОХ АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТИЙН ТАЛААР

Монголбанк нь Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсэгт “Улсын Их Хуралд Монголбанк санхүүгийн тайлангаа аудитын санал, дүгнэлт болон Хяналтын зөвлөлийн санал, зөвлөмжийн хамт жил бүр Улсын Их Хуралд танилцуулна.” гэж заасны дагуу Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хөндлөнгийн аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлангаа, дүгнэлтийн хамт тайлагнасан.

Монголбанк нь Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсэг, Аудитын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу жил бүрийн санхүүгийн тайлангаа олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нэр хүнд бүхий хөндлөнгийн аудитын байгууллагаар баталгаажуулж, цахим хуудсандаа байршуулан олон нийтэд мэдээлдэг.

2018-2022 онд хөндлөнгийн аудитын байгууллагаас Монголбанкны санхүүгийн тайланд аудит хийж, хүснэгт 1-т харуулсан дараах шалтгааны улмаас “Хязгаарлалттай”¹ дүгнэлт өгсөн байна.

Хүснэгт 1. Монголбанкны 2018-2022 оны санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт

Он	Аудитын компанийн нэр	Санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт	Дүгнэлтийн үндэслэл
2018	“Прайсуотерхаус Куперс Аудит” ХХК	Хязгаарлалттай дүгнэлт	Банкны эрдэнэсийн санд 916,278 сая төгрөгийн /2019.12.31-ний өдрийн байдлаар/ дансны үнэтэй зооснууд багтсан. Энэ нь 1925 онд тухайн үеийн Төв банкнаас анх гүйлгээнд гаргасан мөнгөн зоос юм. Эдгээр зооснуудыг банкны дотоод бодлого, журмын дагуу эрдэнэсийн сангийн хөрөнгө гэж үзсэн хангалттай зохистой аудитын нотлох баримт олж авах боломжгүй байжээ. Банкны нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу банкнаас зоос болон мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд гаргах үед нэрлэсэн өртгөөр өр төлбөр хэсэгт бүртгэх бөгөөд гүйлгээнээс татсан зоос болон мөнгөн тэмдэгтийг хөрөнгөөр хүлээн зөвшөөрдөггүй байна. Харин Монголбанк нь зооснуудыг гүйлгээнд гаргасан хэдий ч Засгийн газраас тус зооснуудыг Эрдэнэсийн санд хандивласан учир эдгээр зоосыг хөрөнгөөр хүлээн зөвшөөрч болно гэж Төв банкны удирдлага үзсэн байна. Мөн Санхүүгийн байдлын тайланд тусгагдсан зоосны үнэлгээнд хөндлөнгийн аудитын байгууллагын шинжээчид итгэл үнэмшил олж авч чадаагүй байна.
2019	"Эрнст энд янг Монголия аудит" ХХК	Хязгаарлалттай дүгнэлт	
2020	"Эрнст энд янг Монголия аудит" ХХК	Хязгаарлалттай дүгнэлт	
2021	“Прайсуотерхаус Куперс Аудит” ХХК	Хязгаарлалттай дүгнэлт	
2022	“Прайсуотерхаус Куперс Аудит” ХХК	Хязгаарлалттай дүгнэлт	

¹ Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 203 дугаар тушаалаар батлагдсан “Санхүүгийн тайлангийн аудитын журам”-ын 2.20.2-д заасны дагуу хязгаарлалттай санал дүгнэлтийг дараах үндэслэлээр өгдөг. Үүнд: 1.Аудитор санхүүгийн тайлангуудын нэг буюу хэсэг зүйлсийг зөвшөөрөөгүй, 2.Илэрсэн алдаа, зөрчил, дутагдал нь материаллаг боловч суурь шинжтэй, 3.Төсвийн санхүүгийн тайлангийн хувьд төсвийн хуулиар зөвшөөрөгдсөн зардлын хэмжээг хэтрүүлсэн бол хязгаарлалттай санал, дүгнэлт өгөх үндэслэл болно.

Монголбанкны тухай хуулийн 41 дүгээр зүйлд заасны дагуу Монголбанкны санхүүгийн тайлангийн бүрдүүлбэр нь тэнцэл, орлого, зарлагын тайлан, бусад холбогдох тайлан, нэмэлт тайлбар, тодруулгаас бүрдэж байна.

Хүснэгт 2. Монголбанкны 2018-2022 оны санхүүгийн тайлангийн үндсэн үзүүлэлт /сая төгрөг/

Үзүүлэлт	2018	2019	2020	2021	2022	Өөрчлөлт	
						Дүн	Хувь
Нийт хөрөнгө	14,835,365	17,414,807	19,096,373	20,612,704	21,204,652	591,948	2.9
Нийт өр төлбөр	16,711,360	19,313,111	21,405,656	23,984,760	26,334,764	2,350,004	9.8
Нийт өөрийн хөрөнгө	(1,875,995)	(1,898,304)	(2,309,283)	(3,372,056)	(5,130,112)	(1,758,056)	52.1
Хуримтлагдсан алдагдал	(3,071,835)	(3,698,110)	(4,327,545)	(5,359,185)	(7,087,754)	(1,728,569)	32.3

Монголбанкны 2022 оны жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайланг авч үзвэл, 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийтдээ 21,204,652 сая төгрөгийн хөрөнгө бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 591,948 сая төгрөг буюу 2.9 хувиар өссөн байна.

Мөн нийт өр төлбөр 26,334,764 сая төгрөг байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2,350,004 сая төгрөг буюу 9.8 хувиар өссөн байна. Харин нийт өөрийн хөрөнгийн хэмжээ -5,130,112 сая төгрөг болж 52.1 хувиар буурсан бөгөөд хуримтлагдсан алдагдал -7,087,754 сая төгрөг болж 32.3 хувиар өссөн байна.

Нийт хөрөнгийн өсөлтөд дотоодын банкуудад олгосон зээл 2021 оноос 439,778 сая төгрөг буюу 29.6 хувиар, Засгийн газраас авах авлага 514,942 сая төгрөг буюу 100 хувиар, борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө 28,907 сая төгрөг буюу 5.7 дахин тус тус нэмэгдсэн нь голлох нөлөө үзүүлсэн байна.

Дээрх үзүүлэлтүүдээс Засгийн газраас авах авлагын талаар санхүүгийн тайлангийн тодруулгын хэсэгт дэлгэрэнгүй байдлаар тайлагнаагүй, мөн борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгийн талаар санхүүгийн тайланд тодруулаагүй байна.

Хүснэгт 3. Монголбанкны 2021-2022 оны хөрөнгийн үзүүлэлтийн харьцуулалт /сая төгрөг/

Д/д	Үзүүлэлт	2021	2022	Өөрчлөлт	
				Дүн	Хувь
1	Бэлэн мөнгө	177,591	166,906	(10,685)	-6.0
2	Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө	4,473,789	3,988,528	(485,261)	-10.8
3	Дотоодын банкуудад олгосон зээл	1,487,308	1,927,086	439,778	29.6
4	Буцаан худалдан авах хэлцлийн авлага	-	94,864	94,864	-
5	Өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалт	6,393,822	6,034,122	(359,700)	-5.6
6	Өмчийн үнэт цаасны хөрөнгө оруулалт	6,533	6,533	-	0.0
7	Урвуу буцаан худалдан авах хэлцэл	4,522,220	5,220,845	698,625	15.4

8	Алт ба үнэт металл	1,685,633	1,706,031	20,398	1.2
9	Эрдэнэсийн сан	1,115,085	1,091,554	(23,531)	-2.1
10	Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	77,103	114,739	37,636	48.8
11	Засгийн газрын үнэт цаас	231,778	38,646	(193,132)	-83.3
12	Засгийн газраас авах авлага	-	514,942	514,942	100.0
13	Бусад хөрөнгө	319,721	150,240	(169,481)	-53.0
14	Үндсэн ба биет бус хөрөнгө	116,024	114,612	(1,412)	-1.2
15	Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө	6,097	35,004	28,907	5.7 дахин
Нийт хөрөнгө		20,612,704	21,204,652	591,948	2.9

Нийт өр төлбөрийн өсөлтөд Засгийн газрын хөрөнгө 2021 оноос 1,426,822 сая төгрөг буюу 82.3 хувиар, дотоодын банкуудын хөрөнгө 3,663,757 сая төгрөг буюу 81.9 хувиар, санхүүгийн үүсмэл хэрэгсэл 471,093 сая төгрөг буюу 100.3 хувиар, буцаан худалдан авах хэлцэл 95,857 сая төгрөг буюу 100 хувиар тус тус нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Хүснэгт 4. Монголбанкны 2021-2022 оны нийт өр төлбөрийн харьцуулалт /сая төгрөг/

Д/д	Үзүүлэлт	2021	2022	Өөрчлөлт	
				Дүн	Хувь
1	Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	1,105,589	1,089,243	(16,346)	-1.5
2	Төв банкны үнэт цаас	8,622,184	5,641,303	(2,980,881)	-34.6
3	Засгийн газрын хөрөнгө	1,734,116	3,160,938	1,426,822	82.3
4	Дотоод банкуудын хөрөнгө	4,471,877	8,135,634	3,663,757	81.9
5	Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	469,758	940,851	471,093	100.3
6	Гадаад өр төлбөр	6,914,005	6,874,737	(39,268)	-0.6
7	Буцаан худалдан авах хэлцэл	-	95,857	95,857	100.0
8	Бусад өр төлбөр	667,231	396,201	(271,030)	-40.6
Нийт өр төлбөр		23,984,760	26,334,764	2,350,004	9.8

Дээрх үзүүлэлтүүдээс Засгийн газрын хөрөнгө өсөхөд Монголбанканд байршуулсан Сангийн яамны харилцах данснууд нэмэгдсэн нь нөлөөлсөн, бол дотоодын банкуудын хөрөнгө өсөхөд гадаад валютын харилцах, гадаад валютын хугацаатай хадгаламжууд нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Нийт өөрийн хөрөнгийн бууралт нь өмнөх оноос тайлант онд хуримтлагдсан алдагдал 1,728,569 сая төгрөгөөр буюу 32.3 хувиар өссөн, бусад нөөц 29,487 сая төгрөг буюу 1.5 хувиар буурсантай тус тус холбоотой байна.

Хүснэгт 5. Монголбанкны 2021-2022 оны нийт өөрийн хөрөнгийн харьцуулалт /сая төгрөг/

Д/д	Үзүүлэлт	2021	2022	Өөрчлөлт	
				Дүн	Хувь
1	Дүрмийн сан	60,000	60,000	-	0.0
2	Хуримтлагдсан алдагдал	(5,359,185)	(7,087,754)	(1,728,569)	32.3
3	Бусад нөөц	1,927,129	1,897,642	(29,487)	-1.5
Нийт өөрийн хөрөнгө		(3,372,056)	(5,130,112)	(1,758,056)	52.1

Мөн орлого үр дүнгийн болон бусад орлогын дэлгэрэнгүй тайланг авч үзвэл, 2022 онд 1,758,056 сая төгрөгийн алдагдалтай ажилласан бөгөөд энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 695,283 сая төгрөг буюу 65.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 6. Монголбанкны 2018-2022 оны орлого, үр дүнгийн болон бусад орлогын тайлан /сая төгрөг/

Үзүүлэлт	2018	2019	2020	2021	2022	Өөрчлөлт	
						Дүн	Хувь
Хүүгийн орлого	517,004	724,318	234,362	286,227	400,577	114,350	40.0
Бусад адилтгах орлого	-	-	42,810	22,165	10,535	(11,630)	-52.5
Хүүгийн зардал	(921,433)	(1,182,320)	(816,411)	(886,262)	(930,354)	(44,092)	5.0
Эрсдэлийн алдагдлын сангийн зардал	-	-	(81,355)	(95,118)	(114,970)	(19,852)	20.9
ЭАС-ийн зардлын дараах хүүгийн цэвэр зардал	(404,429)	(458,002)	(620,594)	(672,988)	(634,212)	38,776	-5.8
Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй ашиг (алдагдал)	1,359,055	435,693	209,615	(389,785)	(1,123,844)	(734,059)	188.3
Тайлант жилийн нийт алдагдал	954,626	(22,309)	(410,979)	(1,062,773)	(1,758,056)	(695,283)	65.4

Дээрх тайлангийн үйл ажиллагааны орлого болон захиргааны ба үйл ажиллагааны бусад зардлыг хүснэгт 7-д харуулсан бөгөөд 2022 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар үйл ажиллагааны бусад орлого өмнөх оноос 33.2 хувиар, захиргааны ба үйл ажиллагааны бусад зардал 10.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 7. Монголбанкны 2019-2022 оны үйл ажиллагааны бусад орлого, захиргааны ба үйл ажиллагааны бусад зардлын харьцуулалт /сая төгрөг/

Үзүүлэлт	2019	2020	2021	2022	Өөрчлөлт	
					Дүн	Хувь
Үйл ажиллагааны бусад орлого	28,847	29,623	29,368	39,105	9,737	33.2
Захиргааны ба үйл ажиллагааны бусад зардал	(55,735)	(65,464)	(66,017)	(73,065)	(7,048)	10.7
Үүнээс;						
Цалин урамшууллын зардал	20,231	23,310	25,472	29,650	4,178	16.4
Мөнгөн тэмдэгт хэвлүүлэх зардал	11,527	15,549	9,928	13,657	3,729	37.6
Харилцаа холбоо ашиглалтын зардал	1,823	2,034	2,366	2,517	151	6.4
Байгууламж, зохион байгуулалтын төлбөр	-	-	1,766	1,767	1	0.1

Харуул хамгаалалтын зардал	1,382	1,657	1,766	1,767	1	0.1
Системийн засварын зардал	860	1,008	884	1,566	682	77.1
Тээврийн болон албан томилолтын зардал	-	-	783	996	213	27.2
Сургалтын зардал	463	209	112	274	162	144.6
Бусад зардал	6,418	4,485	5,201	5,975	774	14.9

Тайлбар: Монголбанкны цахим хуудсанд байршуулсан 2019.12.31-ний өдрөөрх аудитлагдсан санхүүгийн тайлангийн тодруулгын тайлангийн хуудас дутуу байсан /29-43 дугаар хуудас/ тул 2018 оны үйл ажиллагааны орлого болон захиргааны ба үйл ажиллагааны бусад зардлын үзүүлэлтийг оруулаагүй болно.

Захиргааны болон үйл ажиллагааны бусад зардал өмнөх оноос 7,048 сая төгрөг буюу 10.7 хувиар өсөхөд дараах зардлууд голлох нөлөө үзүүлжээ. Үүнд:

- сургалтын зардал 162 сая төгрөг буюу 144.6 хувиар;
- системийн засварын зардал 682 сая төгрөг буюу 77.1 хувиар;
- мөнгөн тэмдэгт хэвлүүлэх зардал 3,729 сая төгрөг буюу 37.6 хувиар;
- цалин урамшууллын зардал 4,178 сая төгрөг буюу 16.4 хувиар;
- бусад зардал 774 сая төгрөг буюу 14.9 хувиар тус тус өссөн.

ХОЁР.МОНГОЛБАНКНЫ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ, ТҮҮНИЙ САНАЛ, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 27¹ дүгээр зүйлийн 27^{1.1} дэх хэсэгт “Монголбанкны дотоод хяналтын үйл ажиллагаа, хөндлөнгийн аудитын санал, зөвлөмжийн хэрэгжилт, хөрөнгө оруулалтын багц болон Монголбанкнаас санхүүгийн тайлангаа Улсын Их Хурал, олон нийтэд тайлагнаж, мэдээлж байгаа байдал, Монголбанкны Зөвлөлийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавих эрх бүхий орон тооны бус Хяналтын зөвлөл ажиллана. Хяналтын зөвлөлийн ажиллах журмыг Улсын Их Хурал тогтооно.” гэж заасан.

Мөн хуулийн 27¹ дүгээр зүйлийн 27^{1.3} дахь хэсэгт заасны дагуу Монголбанкны Хяналтын зөвлөл /цаашид “Хяналтын зөвлөл” гэх/ нь дарга, 6 гишүүнээс бүрдэх бөгөөд Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнийг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны санал болгосноор Улсын Их Хурлаас **зургаан жилийн хугацаатай** томилж, чөлөөлдөг. Улсын Их Хурлын Тамгын газраас Улсын Их Хурлаас томилогддог албан тушаалтнуудын бүрэн эрхийн хугацаанд хяналт тавих чиг үүргийн хүрээнд Хяналтын зөвлөлийн дарга, гишүүдийн бүрэн эрхийн хугацааг хянан үзвэл 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрөөр дуусгавар болсон байна.

Хүснэгт 8.Хяналтын зөвлөлийн дарга, гишүүдийн бүрэн эрхийн хугацааны талаарх мэдээлэл

Д/д	Албан тушаал	Овог, нэр	Томилогдсон огноо, дугаар	Бүрэн эрхийн хугацаа дуусах огноо
1.	Хяналтын зөвлөлийн дарга	Д.Даваасамбуу	УИХ-ын 2017.01.12-ны өдрийн №03 тогтоол	2023.01.12-нд бүрэн эрхийн хугацаа дууссан
2.	зөвлөлийн гишүүн	Л.Ариунаа		
3.	зөвлөлийн гишүүн	Л.Дондог		
4.	зөвлөлийн гишүүн	Б.Лхагважав		

5.	зөвлөлийн гишүүн	Б.Цэрэнбалтав		
6.	зөвлөлийн гишүүн	Ч.Чимидсүрэн		
7.	зөвлөлийн гишүүн	М.Энх-Амгалан		

Хяналтын зөвлөл нь 2022 онд Монголбанкны санхүүгийн тайлан, орлого, зарлагын байдал, хөрөнгийн хүрэлцээ, алдагдлын шалтгаан нөхцөл, авлага, зээлийн хүү, ханшийн зөрүүний асуудал, мөнгөний бодлогын үр дүн, банкны актив дахь дотоод, гадаад хөрөнгө оруулалтын багц, дотоод аудит, хөндлөнгийн аудит, эрсдэлийн удирдлага, Монголбанкны өөрийнх нь төсөв, түүний зарцуулалт зэрэг өргөн цар хүрээтэй асуудлыг хэлэлцэж, холбогдох санал, зөвлөмжөө хүргүүлж ажиллажээ.

2022 онд нийт 6 удаа хуралдаж, 20 орчим асуудал хэлэлцэж, Хяналтын зөвлөлийн тогтоолоор 5 санал, зөвлөмжийг Монголбанканд хүргүүлжээ. Мөн Хяналтын зөвлөлөөс хүргүүлж буй санал, зөвлөмжийн хэрэгжилтийн үр нөлөөг сайжруулах зорилгоор хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан санал, зөвлөмжөө хүргүүлэх бодлого баримтлан ажилласан бөгөөд энэ хүрээнд 2022 онд нийт 6 удаа хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан 11 санал, зөвлөмжийг Монголбанканд хүргүүлсэн байна.

2023 онд Хяналтын зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа дуусгавар болж байгаатай холбогдуулан Хяналтын зөвлөлийн тогтоол, албан бичиг, хурлын тэмдэглэлээр 2017-2021 онд Монголбанканд хүргүүлсэн нийт 50 санал, зөвлөмжийн хэрэгжилтийг 2022 онд хянан хэлэлцсэн бөгөөд Монголбанкнаас нийт санал, зөвлөмжийн хэрэгжилтийг 94.3 хувийн биелэлттэй гэж тайлагнажээ.

Харин Улсын Их Хурлын Тамгын газраас Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасан аргачлалын дагуу санал, зөвлөмжийн хэрэгжилтийг хянан үзэж нийт санал, зөвлөмжийн хэрэгжилтийн дундаж 85.4 хувьтай гэж үнэлсэн.

Хүснэгт 9. УИХТГ-аас Хяналтын зөвлөлөөс Монголбанканд хүргүүлсэн санал, зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлсэн байдал

2017-2021 онд Хяналтын зөвлөлөөс Монголбанканд хүргүүлсэн санал, зөвлөмжийн хэрэгжилтийн үнэлгээ	Санал, зөвлөмжийн тоо
Үүнээс:	50
- Бүрэн хэрэгжсэн буюу 100%	35
- Хэрэгжих шатанд буюу 70%	8
- Хэрэгжилт хангалтгүй буюу 30%	7
- Хэрэгжээгүй буюу 0%	-
НИЙТ ДУНДАЖ	85.4%

Нийт хүргүүлсэн 50 санал, зөвлөмжөөс бүрэн хэрэгжсэн буюу 100 хувийн хэрэгжилттэй 35 санал, зөвлөмж, хэрэгжих шатанд буюу 70 хувийн хэрэгжилттэй 8 санал, зөвлөмж, хэрэгжилт хангалтгүй буюу 30 хувийн хэрэгжилттэй 7 санал, зөвлөмж байна. Хэрэгжилт хангалтгүй 7 санал, зөвлөмжийг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 10. Хяналтын зөвлөлөөс Монголбанканд хүргүүлсэн санал, зөвлөмжөөс хэрэгжилт хангалтгүй санал, зөвлөмжийн жагсаалт

Д/д	Хэрэгжилт хангалтгүй санал, зөвлөмж	УИХТГ-ын үнэлгээ
1	Монголбанк өөрийн үйл ажиллагаандаа эрсдэлийн удирдлагын үнэлгээг хийж ажиллахыг зөвлөсүгэй;	30%
2	Монголбанкны үйл ажиллагаа, удирдлагад хамаарах гадаад зээлийн хүүгийн хэмжээг Олон Улсын Валютын Сантай ойлголцсон хэмжээнд хүртэл буулгах, богино хугацаат гадаад өрийг яаралтай барагдуулах чиглэлээр ажиллахыг санал болгосугай;	30%
3	Банкны 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлант жилийн алдагдал 1,647,585 сая төгрөг, нийт хуримтлагдсан алдагдал 3,019,323 сая төгрөг (сөрөг 3 их наяд 19 тэрбум 323 сая төгрөг)-т хүрээд байна. Төв банкны тухай хуулийн 38 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаж ажиллах үүрэгтэй ба холбогдох асуудлыг Улсын Их Хуралд танилцуулж шийдвэрлүүлэхэд онцгойлон анхаарч ажиллах шаардлагатай байна;	30%
4	Монголбанкны дотоод аудитын хамрах хүрээ, эрх хэмжээ, хяналт шалгалтын үйл ажиллагааг сайжруулж, төгөлдөржүүлэх;	30%
5	Монголбанк төсөвт зардал, түүний хуваарилалтыг өөрийн үндсэн зорилт, чиг үүрэгтэй холбон авч үзэж дүгнэж байх, суурь, урсгал зардлыг нормчлох, зардлын өсөлтийг хязгаарлах боломжийг судлах;	30%
6	Таваарын бүтээгдэхүүний үнийн мөчлөг, ирээдүйн гадаад өр төлбөрийн хуваарь зэргийг бодолцон гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, зэс, нүүрс, алт зэрэг голлох экспортын бүтээгдэхүүний орлогын дийлэнхийг дунд хугацаанд Монголдоо үлдээх стратеги төлөвлөгөөг холбогдох байгууллагуудтай хамтран боловсруулж, хэрэгжүүлж ажиллах;	30%
7	Монгол дахь банкны төлбөрийн чадваргүйдлийн талаарх өмнөх шийдвэрүүдийн хэрэгжилтийн үр дүнг олон улсын шилдэг туршлага, Монгол Улсын онцлогтой холбон судалж, оновчтой хувилбарыг олох, улсыг хохиролд оруулахаас сэргийлэх.	30%

Хяналтын зөвлөл нь Улсын Их Хурлын 2003 оны 39 дүгээр тогтоолоор баталсан “Монголбанкны Хяналтын зөвлөлийн ажиллах журам”-ын 2.1-д заасан чиг үүргийг хэрэгжүүлж ажилладаг.

Тус журмын 2.1.1-д “*үйл ажиллагаа нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын зарчимд нийцсэн хөндлөнгийн аудитын байгууллагыг Монголбанкны жилийн санхүүгийн тайланд аудит хийлгэхээр сонгох явцад хяналт тавих*” гэж заасан.

Монголбанкны санхүүгийн үйл ажиллагаанд аудитын байгууллагыг сонгохдоо Монголбанкны Ерөнхийлөгч, түүний томилсон гүйцэтгэх удирдлагаас бүрдсэн ажлын хэсэг шийдвэр гаргадаг байсан бол Хяналтын зөвлөлөөс өгсөн санал, зөвлөмжийн дагуу Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн А-242 дугаар тушаалаар “Монголбанкны санхүүгийн тайланд аудит хийх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах журам” батлагдсан байна. Тус журамд аудит хийх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах ажлын хэсэгт Хяналтын зөвлөлийн төлөөллийг оролцуулах зохицуулалтыг тусгаснаар Хяналтын зөвлөлөөс хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгох явцад хяналт тавих нөхцөл бүрдсэн байна.

Мөн Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 27¹.9.2-д “Монголбанкны дотоод аудитын газрын хянан шалгагч болон тус банкны санхүүгийн тайланд

аудит хийсэн байгууллагын аудитортой харилцаж, санал солилцох,” гэж заасны дагуу Хяналтын зөвлөл нь 2022 онд Монголбанкны санхүүгийн тайланд аудит хийж буй компанийн аудиторуудтай нийт 2 удаагийн уулзалт зохион байгуулжээ.

Журмын 2.1.2-т “хөндлөнгийн аудитын дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар Монголбанкнаас хийж буй ажилтай танилцаж, биелэлтэд хяналт тавих” гэж, 2.1.3-т “хөндлөнгийн аудитын үйл ажиллагаа нягтлан бодох бүртгэлийн олон улсын зарчимд нийцэж явагдаж байгаа эсэхийг хянах” гэж тус тус заасан.

Хөндлөнгийн аудитын дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар Монголбанкнаас хийж буй ажилтай танилцаж, биелэлтэд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд Монголбанкны 2022 оны санхүүгийн аудитлагдсан тайлантай танилцаж, холбогдох санал, зөвлөмжийг Монголбанканд хүргүүлжээ. Мөн Хяналтын зөвлөлийн 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 6 дугаартай албан бичгээр “Монголбанкны 2022 оны аудитлагдсан санхүүгийн тайланд өгсөн санал, зөвлөмж”-ийг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлсэн байна.

Мөн Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу Монголбанк нь санхүүгийн тайлангаа олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу гүйцэтгэж тайлагнасан байна. Энэ талаар хөндлөнгийн аудитын байгууллагын тайлан болон Хяналтын зөвлөлийн тайлангийн дүгнэлтээр баталгаажуулжээ.

Хяналтын зөвлөлөөс 2017-2021 оны Монголбанкны аудитлагдсан санхүүгийн тайланд нийт 9 санал, зөвлөмжийг давхардсан тоогоор 14 удаа Монголбанканд хүргүүлсэн байна. Нийт хүргүүлсэн санал, зөвлөмжөөс Монголбанк 7 санал, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, дараах 2 санал, зөвлөмж хэрэгжилтийн шатанд байна. Үүнд:

1. Хараат бус аудиторуудаас СТОУС 9-ийн өөрчлөлтүүдтэй банкны санхүү, бүртгэлийн үйл ажиллагаа, тооцооллын аргачлалыг нийцүүлэх талаар өгсөн зөвлөмж, ялангуяа мэдээллийн технологийн систем дэх мэдээллийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, кибер аюулгүй байдлыг хангах талаар удаа дараалан өгч байгаа зөвлөмжийг нэн даруй хэрэгжүүлэх;
2. Монголбанкнаас гаргаж буй аливаа зээлийн хүүг Монголбанкны нийт эх үүсвэрт бодогддог хүүнээс доогуур олгохыг зогсоох.

Хүснэгт 11. Хяналтын зөвлөлөөс Монголбанкны аудитлагдсан тайланд өгсөн санал, зөвлөмжийн талаарх мэдээлэл

Д/д	Тайлангийн нэр	Санал, зөвлөмжийн тоо	Тайлбар
1	2017 оны аудитлагдсан санхүүгийн тайлан	2	- биелсэн 2
2	2018 оны аудитлагдсан санхүүгийн тайлан	2	- биелсэн 1, - хэрэгжилтийн шатанд 1.
3	2019 оны аудитлагдсан санхүүгийн тайлан	1	- биелсэн 2
4	2020 оны аудитлагдсан санхүүгийн тайлан	2	- биелсэн 2
5	2021 оны аудитлагдсан санхүүгийн тайлан	2	- биелсэн 1,

		- хэрэгжилтийн шатанд 1.
НИЙТ		9

Нийт хүргүүлсэн санал, зөвлөмжөөс хэрэгжилт хангалтгүй дараах санал, зөвлөмжийг Монголбанканд дахин хүргүүлсэн байна. Үүнд:

- банкны санхүүгийн байдлыг тогтворжуулах хөтөлбөр боловсруулах талаарх зөвлөмжийг 2017, 2018 онуудад;
- 1925 оны зоостой холбоотой зөвлөмжийг 2019, 2020, 2021 онуудад;
- Монголбанкны алдагдалтай холбоотой зөвлөмжийг 2020, 2021 онуудад тус тус хүргүүлжээ.

Мөн хараат бус хөндлөнгийн аудитын байгууллагаас Монголбанкны 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн 8 зөвлөмжөөс 2022 онд бүрэн хэрэгжүүлсэн 3 зөвлөмж, хэрэгжих шатанд байгаа 4 зөвлөмж, хэрэгжээгүй 1 зөвлөмж байна гэж Хяналтын зөвлөл дүгнэсэн байна.

Журмын 2.1.5-д заасан “Монголбанкнаас Улсын Их Хурал, олон нийтэд мэдээлсэн санхүүгийн тайлантай танилцаж, дүгнэлт өгөх” гэж заасан.

Төвбанкны тухай хуулийн 30 дугаар зүйлд заасны дагуу Монголбанк тайлан, мэдээллээ Улсын Их Хуралд хүргүүлж, олон нийтэд нээлттэй мэдээлж ирсэн. Энэ хүрээнд Монголбанкнаас жил бүр 10 гаруй тайланг сар, улирал, жилийн давтамжтай хүргүүлж байгаа бөгөөд Хяналтын зөвлөлөөс тухай бүр мэдээлэлтэй танилцаж холбогдох саналаа хүргүүлж иржээ.

Монголбанк нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулж Монголбанкны бодлого, шийдвэрийг олон нийтэд түгээх олон нийттэй харилцах сувгуудыг хөгжүүлэх бодлого баримтлан ажиллаж байгаа бөгөөд Хэвлэл мэдээллийн алба, Олон нийтийн санхүүгийн боловсролын төв зэрэг зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийг бий болгож “ил тод байдал, харилцаа, боловсрол” гэсэн 3 чиглэлд анхаарч ажиллаж байна.

Журмын 2.1.4-т заасан “Монголбанкны Зөвлөлийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавих”, 2.1.6-д заасан “дотоод хяналтын талаар гаргасан журам, дотоод хяналтын үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөө, тэдгээрийн хэрэгжилтийн байдалтай танилцаж, холбогдох арга хэмжээ авахыг Монголбанкны удирдлагад санал болгох”, 2.1.7-д заасан “хөрөнгө оруулалтын багцад хяналт тавих” гэсэн чиг үүргийг Хяналтын зөвлөлөөс үр дүнтэй хэрэгжүүлэх эрх зүйн орчин тодорхойгүй байгаа талаар тайланд дурдсан бөгөөд энэ талаарх зохицуулалтыг боловсронгуй болгох саналаа Улсын Их Хуралд хүргүүлсэн байна.

ГУРАВ.ТӨВ БАНК /МОНГОЛБАНК/-НЫ ТУХАЙ ХУУЛЬД ЗААСАН МОНГОЛБАНКНЫ ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТӨВЧ МЭДЭЭЛЭЛ

Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд заасны дагуу Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийн болон санхүүгийн зах зээл, банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангах замаар үндэсний эдийн засгийн тэнцвэртэй хөгжилд дэмжлэг үзүүлэх юм.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхдээ Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан дараах чиглэлийн үйл ажиллагааг Монголбанк эрхэлнэ гэж заасан. Үүнд:

- мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах, зохицуулах;
- мөнгөний бодлого боловсруулах, хэрэгжүүлэх;
- засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үүрэг гүйцэтгэх;
- банк болон хуульд тусгайлан заасан этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих;
- үндэсний төлбөрийн систем, түүний үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих;
- гадаад валютын улсын нөөцийг эзэмших, удирдах;
- банкны харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;
- макро зохистой бодлого хэрэгжүүлэх зэрэг болно.

1.1. Мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах, зохицуулах хүрээнд

2022 оны жилийн эцсийн байдлаар гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний хэмжээ мөнгөн дүнгээр 1.089 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.5 хувь буюу 16.3 тэрбум төгрөгөөр буурчээ. Харин гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний тоо ширхэг өмнөх оноос 2.0 хувь буюу 10.8 сая ширхгээр өсөж, 537.2 сая ширхэгт хүрсэн байна.

Хүснэгт 12.2022 оны жилийн эцсийн байдлаарх гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний хэмжээ

№	Мөнгөн дэвсгэрт	Мөнгөн дүн (сая төгрөгөөр)		Тоо ширхэг (сая ширхэгээр)	
		2021	2022	2021	2022
1	1 төгрөг	33.6	34.1	33.6	34.1
2	5 төгрөг	152.6	154.9	30.5	31.0
3	10 төгрөг	1,072.2	1,111.1	107.2	111.1
4	20 төгрөг	1,800.1	1,845.8	90.0	92.3
5	50 төгрөг	3,817.8	3,958.7	76.4	79.2
6	100 төгрөг	7,460.7	7,594.1	74.6	75.9
7	200 төгрөг	36.7	37.0	0.2	0.2
8	500 төгрөг	8,665.8	8,854.2	17.3	17.7
9	1000 төгрөг	20,588.0	21,790.5	20.6	21.8
10	5000 төгрөг	79,927.1	76,435.4	16.0	15.3
11	10000 төгрөг	218,555.0	205,076.0	21.9	20.5
12	20000 төгрөг	763,441.3	762,350.9	38.2	38.1
	Нийт	1,105,550.9	1,089,242.7	526.4	537.2

Гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний дийлэнх хэсгийг өндөр нэрлэсэн дүнтэй дэвсгэртүүд бүрдүүлж байна. 2022 онд 10000 болон 20000 төгрөгийн дэвсгэртүүд мөнгөн дүнгийн 88.8 хувийг эзэлж байгаа нь өндөр нэрлэсэн дүнтэй мөнгөн дэвсгэртүүдийн эрэлт жил бүр нэмэгдсээр байгаатай холбоотой гэж үзжээ. Харин бусад дэвсгэртүүдийн эзлэх хувь өмнөх оноос 0.9 нэгж хувиар буурч 11.2 хувьд хүрсэн байна.

1.2. Мөнгөний бодлого боловсруулах, хэрэгжүүлэх хүрээнд

Монгол Улсын инфляцын түвшинг +/-2 нэгж хувийн интервалтай 6 хувь орчимд тогтворжуулах зорилт тавьсан бөгөөд 2022 оны жилийн эцсийн байдлаар инфляц улсын хэмжээнд 13.2 хувь, Улаанбаатар хотод 12.9 хувьтай байна. Инфляц зорилтот түвшнээс өндөр байхад дараах хүчин зүйлс нөлөөлсөн гэж Монголбанк үзсэн байна. Үүнд:

- Тээвэр, логистикийн нөхцөл сайжирсан ч тээврийн зардал хэвийн үеэс 2 дахин өндөр;
- Худалдааны орнуудын өндөр инфляц, төгрөгийн ханш суларсан зэргээс шалтгаалан импортын барааны үнэ нэмэгдсэн;
- Шатахууны үнийн өсөлттэй холбоотойгоор дотоодын бараа бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн зардал нэмэгдэж үнэ өссөн зэрэг нь инфляц өндөр байхад голлох нөлөөг үзүүлсэн байна.

2022 оны сүүлийн хагас жилд тээврийн саатал багасаж, импортын хүнсний үнийн өсөлт саарч, шатахууны үнийн өсөлт тогтворжиж инфляц алгуур буурч эхэлсэн хэдий ч макро эдийн засгийн эрсдэл, эмзэг байдал буураагүй, төлбөрийн тэнцлийн алдагдал тэлсэн, гадаад суурь хүү хүлээлтээс хурдан өссөн зэргээс шалтгаалан Монголбанкны мөнгөний бодлогын хороо 2022 онд ээлжит болон ээлжит бус нийт 5 удаа хуралдаж мөнгөний бодлогын төлөвийг чангаруулах шийдвэр гаргаснаар бодлогын хүүг 13 хувьд хүргэжээ.

Мөнгөний хатуу бодлогын нөлөөгөөр мөнгөний нийлүүлэлтийн өсөлт харьцангуй тогтворжиж жилийн эцсийн байдлаар 29,651 сая төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 6.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Мөнгөний нийлүүлэлтийг бүрэлдэхүүнээр нь авч үзвэл төгрөгийн хадгаламж 16.2 хувиар буурч, гадаад валютын хадгаламж 23.6 хувиар өсөж, гадаад валютын гүйлгээ өмнөх оны мөн үеэс 2 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Монголбанкнаас зарласан төгрөгийн ам.доллартой харьцах ханш 2022 оны жилийн эцэст 3,444.6 төгрөгт хүрсэн нь оны эхэн үетэй харьцуулахад 20.89 хувиар өсжээ.

Монголбанк 2022 онд хугацаа, хүү, арилжаалах хэлбэрээр ялгаатай дараах Төв банкны үнэт цаасны арилжааг хийсэн байна. Үүнд:

- 28 хоногтой Төв банкны үнэт цаасыг тогтмол хүүтэй, хэмжээ хязгаарлаагүй хэлбэрээр долоо хоногийн Даваа гараг бүр;
- 84 хоногтой Төв банкны үнэт цаасыг тогтмол хүүтэй, хэмжээ хязгаарласан хэлбэрээр 2 долоо хоног тутмын Лхагва гарагт зохион байгуулж ирсэн бөгөөд мөнгөний бодлогын шилжих механизмын нөлөөг сайжруулах зорилгоор 84 хоногтой ТБҮЦ-ны арилжааг зогсоож, 196 хоногтой Төв банкны үнэт цаасыг 2022 оны 3 дугаар улиралд нэвтрүүлж, урт хугацаат Төв банкны үнэт цаасны арилжааны нөхцөлийг сайжруулсан байна.

Мөн Мөнгөний бодлогын хорооны 2022 оны 1 дүгээр тогтоолоор уул уурхайн бус экспорт, боловсруулах аж үйлдвэрийн салбарт олгох урт хугацааны

репо² арилжааны хугацааг 3 жил болгон сунгаж, банкуудын эх үүсвэрийг зээл олголтод татан оролцуулахаар шийдвэрлэж, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны А-34 дүгээр тушаалаар урт хугацаат арилжааны нөхцөлд нэмэлт, өөрчлөлт оруулан баталсан байна.

Түүнчлэн нийлүүлэлтийн тасалдлаас үүсэж болзошгүй инфляцын эрсдэлийг бууруулах зорилгоор урт хугацаат репо арилжааны эх үүсвэрээр мах бэлтгэн нийлүүлэгчдэд олгох зээлийн нөхцөлийг шинэчлэн баталжээ.

2022 оны эхний хагас жилд БНХАУ-ын хилийн хязгаарлалттай холбогдуулан манай улсын уул уурхайн салбар уналтад орсон хэдий ч сүүлийн хагаст хилийн хязгаарлалт суларснаар нүүрсний экспортын хэмжээ сард 4 сая тоннд хүрч, уул уурхайн салбар сэргэсэн байна.

1.3.Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үүрэг гүйцэтгэх хүрээнд

Засгийн газар Монголбанкаар дамжуулан 2012 оны 10 дугаар сараас эхлэн Засгийн газрын үнэт цаас /цаашид “ЗГҮЦ” гэх/-ыг анхдагч зах зээл дээр гарган арилжаалж эхэлсэн.

ЗГҮЦ нь санхүүгийн зах зээл дэх хамгийн эрсдэл багатай хөрөнгө оруулалтын хэрэгсэл бөгөөд хүүгийн орлого нь албан татвараас чөлөөлөгддөг давуу талтай байдаг. Мөн ЗГҮЦ-ны тогтмол арилжаа нь эрсдэлгүй хүүгийн жишгийг санхүүгийн захад тогтоох, богино хугацаат хүүгийн урт хугацаат хүүд нөлөөлөх нөлөөллийг тодорхойлох зэргээр санхүүгийн зах зээлийн хөгжлийг олон талаар дэмждэг. Гэвч сангийн яамны шийдвэрийн дагуу 2017 оны 11 дүгээр сараас хойш ЗГҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжаа нээлттэй зарлагдаагүй байна.

2022 онд ЗГҮЦ-ны хоёрдогч зах дээр арилжаа хийгдээгүй бөгөөд Монголбанкаар дамжин арилжаалагдсан ЗГҮЦ-ны үлдэгдэл 2022 оны эцэст 22.5 тэрбум төгрөг байна.

1.4.Банк болон хуульд тусгайлан заасан этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих хүрээнд

Монголбанк нь хадгаламж эзэмшигч, харилцагчийн эрх ашгийг хамгаалах, банкны тогтолцооны найдвартай байдлыг бэхжүүлэх үйл ажиллагааны хүрээнд банкуудын Банкны тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, мөн Монголбанкнаас баталсан журам, зааврыг хэрхэн хэрэгжүүлж байгаад газар дээрх болон зайны хяналт шалгалтыг дараах хэлбэрээр зохион байгуулж байна. Үүнд:

- Эрсдэлд суурилсан газар дээрх хяналт шалгалтыг тухай бүр;
- Зайны хяналт шалгалтыг сар, улирал бүр;
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр хэрэгжүүлэх хяналт шалгалтыг тухай бүр тус тус хэрэгжүүлдэг байна.

² Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны А-192 дугаар тушаалаар батлагдсан “Төв банкны репо санхүүжилтийн журам”-ын 1.2.1-д заасны дагуу “Төв банкны репо санхүүжилт” гэж банк эзэмшиж буй үнэт цаасаа тохиролцсон хугацааны эцэст урьдчилан тохиролцсон үнээр буцаан худалдан авах нөхцөлтэй Монголбанкнаас ашиглах санхүүгийн байнгын хэрэгсэл юм.

Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан удирдамжийн дагуу 2022 онд газар дээрх иж бүрэн хяналт шалгалтыг 4 банканд, хэсэгчилсэн хяналт шалгалтыг тухайлсан банк бүрд нийт 8 удаа хийж гүйцэтгэсэн байна.

Мөн 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр Банкны тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр системд нөлөө бүхий банкууд нээлттэй хувьцаат компани болох эрх зүйн орчин бүрдсэн. Тус нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхтэй холбогдуулан Монголбанкнаас 12 журмыг боловсруулан баталж, банкуудын үйл ажиллагаанд мөрдлөг болгож, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллажээ.

Монголбанкны санаачилгаар банкуудын активын чанар, эрсдэлийн сан болон өөрийн хөрөнгийн хүрэлцээг үнэлэх, гадаад, дотоодын оролцогч талуудыг бодит мэдээллээр хангах зорилгоор нөлөө бүхий банкуудын Активын чанарын хараат бус, хөндлөнгийн үнэлгээг олон улсад нэр хүнд бүхий Казахстан улсын “Price water house Coopers Tax & Advisory LLP” аудитын компаниар гүйцэтгүүлснээр, банкуудын хувьцаа гаргах үйл ажиллагаа амжилттай хэрэгжих нөхцөл бүрдсэн байна.

Түүнчлэн 2022 онд Монголбанкнаас банк болон бусад байгууллагад Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр дараах хяналт шалгалтыг хийсэн байна. Үүнд:

Банканд:

- Зайн хяналтыг 13 удаа;
- Газар дээрх хяналт шалгалтыг 34 удаа;

Банкнаас бусад санхүүгийн байгууллагад:

- Зайн хяналтыг 37 удаа;
- Газар дээрх хяналт шалгалтыг 3,297 удаа;

Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчид:

- Зайн хяналтыг 28 удаа;
- Газар дээрх хяналт шалгалтыг 1,615 удаа;

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид:

- Зайн хяналтыг 9 удаа;
- Газар дээрх хяналт шалгалтыг 22 удаа.

Хяналт шалгалтаар илэрсэн зөрчилд хуульд заасан торгуулийн арга хэмжээ авах, мөн зөрчил дутагдлыг арилгах, үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн үүрэг, даалгаврыг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар тухайн банкуудад өгч, өмнөх хяналт шалгалтаар өгөгдсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг хянан ажилласан байна.

1.5. Үндэсний төлбөрийн систем, түүний үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих хүрээнд

Монголбанк нь Дэлхийн банктай хамтран Монгол Улсын төлбөрийн системийн хөгжлийн чиг баримжааг тодорхойлох, эрх зүйн орчныг бэхжүүлэх, төлбөрийн системийг цаашид хөгжингүй орны жишигт нийцүүлэх зорилгоор 2022 оны 09 дүгээр сард Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайд, Санхүүгийн

зохицуулах хорооны даргын хамтарсан тушаалаар “Монгол Улсын Үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэх стратеги 2022-2026” баримт бичгийг боловсруулж, баталсан байна.

Мөн Азийн хөгжлийн банк, Монголбанкны санхүүжилтээр хэрэгжүүлсэн “Төлбөрийн системийн шинэчлэл төсөл”-ийн үр дүнд Монгол Улсын төлбөр тооцооны систем олон улсын жишигт хүрсэн. Шинээр нэвтрүүлсэн төлбөрийн системүүд болон төлбөрийн системд гарсан давуу талуудыг сурталчлан таниулах зорилгоор “Falk” арга хэмжээг 2022 оны 11 дүгээр сард үндэсний төлбөрийн системийн нийт оролцогч, Азийн хөгжлийн банкны төлөөлөгчдийн оролцоотой зохион байгуулжээ.

Монголбанк болон БНСУ-ын “Кэй Ти” Группийн охин компани болох “Би Си карт” байгууллага хооронд 2022 оны 12 дугаар сард харилцан ойлголцлын санамж бичиг байгуулснаар дотоодын төгрөгийн карт БНСУ-д, “Би Си карт” байгууллагын төлбөрийн карт Монгол Улсад төлбөр тооцоо хийх боломж бүрдэх эхний алхам хийгджээ.

Төлбөрийн системийн оролцогч хоорондын 2022 оны гүйлгээний нийт тоо, дүнг өмнөх онтой харьцуулбал гүйлгээний тоо 53 хувиар, гүйлгээний дүн 3 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Иргэд өдөр тутмын төлбөр тооцоонд бэлэн бус төлбөрийн хэрэгслийг түлхүү ашигладаг болсноор төлбөрийн картын хэрэглээний үзүүлэлт өссөн байна. Банкууд ₮ карт, Виза, Мастеркарт, Юнионпэй, Американ экспресс болон Жэй Си Би гэсэн 6 төрлийн төлбөрийн картыг өөрийн оноосон нэрээр гаргаж байгаагаас үндэсний брэнд ₮ карт хэрэглээ дангаараа 65 хувийг эзэлж байгаа талаар тайланд дурджээ.

Гүйлгээний үзүүлэлтийн хувьд тайлант онд ПОС төхөөрөмжөөр хийгдсэн гүйлгээний тоо хамгийн өндөр буюу 606.6 сая ширхэг, харин гүйлгээний дүнгийн хувьд АТМ, CRM, СDM төхөөрөмжүүдээр хийгдсэн гүйлгээний дүн хамгийн их буюу 32.2 их наяд төгрөгийн үзүүлэлттэй байна. Киоскийн хэрэглээ өссөн бөгөөд гүйлгээний тоо өмнөх оны үзүүлэлтээс 204.6 хувиар, гүйлгээний дүн нь 4054 хувиар тус тус өссөн байна.

Мөн Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн хүрээнд Монголбанк нь төлбөрийн үйлчилгээ үзүүлэх, систем ажиллуулах зөвшөөрөл олгох, зөвшөөрөлтэй этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих журмын дагуу дараах зөвшөөрлийг 2022 онд олгосон байна. Үүнд:

- төлбөрийн карт гаргах зөвшөөрлийг 2 байгууллагад; (М банк хаалттай ХК, Ардкредит ББСБ ХК)
- төлбөрийн карт хүлээн авах зөвшөөрлийг 2 байгууллагад; (М банк хаалттай ХК, Дата бэйнк ХХК)
- төлбөрийн хэрэгсэл – цахим мөнгө гаргах зөвшөөрлийг 1 байгууллагад; (Дата бэйнк ХХК)
- аутсорсингийн үйлчилгээ авах зөвшөөрлийг 1 байгууллагад; (ККТТ ХХК)
- төлбөрийн хэрэгсэл – цахим мөнгө гаргах зөвшөөрлийг хугацаагүй сунгаж 1 байгууллагад (Мобифинанс ББСБ ХХК) тус тус олгосон байна.

1.6. Гадаад валютын улсын нөөцийг эзэмших, удирдах хүрээнд

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, УИХ-ын 2020 оны 32 дугаар тогтоолыг үндэслэн Монголбанкнаас гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх, Алт-2 үндэсний хөтөлбөрийг эрчимжүүлэх зорилгоор 2020 оны 06 дугаар сараас эхлэн алт олборлогч аж ахуй нэгжүүдэд арилжааны банкаар дамжуулан тус хууль хэрэгжсэн 3 жилийн хугацаанд нийт 505.5 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй санхүүжилтийг олгосон байна.


Монголбанк нь 2022 онд 22.9 тонн үнэт металл худалдан авсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10 хувиар өссөн байна. Мөн худалдан авсан үнэт металлыг мөнгөжүүлж, гадаад валютын улсын нөөцийг 878.0 сая ам.доллараар нэмэгдүүлжээ.

Зураг 1. Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ



Монгол Улсын гадаад валютын улсын нөөц 2022 оны эцэст 3,400.0 сая ам.долларт хүрсэн нь 2021 онтой харьцуулахад 22.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Зураг 2. Гадаад валютын улсын нөөц /сая ам.доллар/



Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор батлагдсан Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн үзэл баримтлалд “Гадаад валютын улсын нөөц нь валютын төлбөртэй импортын нэг жил буюу 52 долоо хоногийн хэрэгцээг хангах түвшнээс багагүй байх” гэж заасан хэдий ч 2022 онд гадаад валютын улсын нөөц тогтоолд заасан хэмжээнээс доогуур түвшинд хэвээр байна.

1.7.Банкны харилцагч, хадгаламж эзэмшигчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хүрээнд

Монголбанк 2022 онд хадгаламж эзэмшигч, харилцагчийн эрх ашгийг хамгаалж, банкны тогтолцооны найдвартай байдлыг бэхжүүлэх хүрээнд Банкны тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж болон Монголбанкнаас баталсан журам, зааврын хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажиллажээ.

Мөн Улсын Их Хурлаас 2022 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр “Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль” батлагдсанаар барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд, мөнгөн зээлийн үйл ажиллагааг байнга, ашиг олох зорилгоор эрхлэх иргэнийг бүртгэх, хяналт тавих, тэдгээрээс олгох зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоох, зээл, түүний хүүг төлөх болон мөнгөн зээлийн үйл ажиллагаанд хэрэглэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах эрх зүйн орчин бүрджээ.

Зээлийн мэдээллийн тухай хууль болон Улсын Их Хурлын 2020 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Зээлийн хүү бууруулах стратеги”-ийн хэрэгжилтийг хангах арга хэмжээний хүрээнд зээлийн мэдээллийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн тушаалаар “Бүрэн Скор ЗМС” ХХК болон “Титан Си Ар Эй Зээлийн мэдээллийн сан” ХХК-д олгосон бөгөөд зээлийн мэдээллийн үйлчилгээг хувийн хэвшилд шилжүүлснээр зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагааг олон улсын түвшинд хүргэж хөгжүүлэх, зээлийн оноо /credit scoring/ буюу зээлжих зэрэглэл тооцох, зах зээлд шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ бий болгох, улмаар зээлийн эрсдэлийн зардлыг бууруулах нөхцөл бүрдсэн байна.

Зээлийн мэдээллийн сангийн зорилго нь санхүүгийн зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэгч байгууллагуудын зээлийн эрсдэл, хуримтлагдсан чанаргүй зээл, өр, авлагын хэмжээг бууруулах, зээлдэгчийн санхүүгийн сахилга батыг сайжруулах замаар санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангахад оршдог.

Одоогоор төрийн болон хувийн хэвшлийн нийт 600 орчим хэрэглэгч байгууллагууд зээлийн мэдээллийн санд холбогдсоноор давхардсан тоогоор нийт 2.8 сая орчим зээлийн мэдээлэл бүртгэгдсэн байна.

1.8.Макро зохистой бодлого хэрэгжүүлэх хүрээнд

Монголбанк нь макро зохистой бодлогыг мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлж Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2022 оны 3 дугаар улирлын ээлжит хурлаар эдийн засгийн гадаад, дотоод орчны төлөв, эрсдэлийг харгалзан үзэж банкуудын гадаадын зах зээлээс бонд болон зээл хэлбэрээр 360 хоног ба түүнээс дээш хугацаагаар шинээр татсан эх үүсвэрийг заавал байлгах нөөцийн шаардлагаас чөлөөлөх шийдвэрийг гаргасан байна. Энэ нь банкуудад гадаад валютын эх үүсвэр татах хөшүүргийг бий болгож хөрөнгийн орох урсгал, гадаад тэнцвэрт эерэг нөлөө үзүүлнэ гэж Монголбанк үзсэн байна.

Монголбанкнаас иргэдийн хэрэглээний зээлийн өсөлтийг зохистой түвшинд хадгалах, өрхийн өрийн дарамтыг бууруулах болон банкны системд

эрсдэл хуримтлагдахаас урьдчилан сэргийлэх зорилгоор банкнаас олгох хэрэглээний зээлийн хувьд өр, орлогын харьцаа болон хугацааны хязгаарлалт тогтоон 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдүүлж эхэлсэн. Тус арга хэмжээний үр нөлөөгөөр банкнаас иргэдэд олгосон хэрэглээний зээлийн өсөлт 2019 оноос хойших хугацаанд харьцангуй тогтворжиж, 2018 оны эцэст 49.6 хувьтай байсан хэрэглээний зээлийн жилийн өсөлт 2022 оны эцэст 11.4 хувьд хүрсэн байна.

Гэвч дээрх арга хэмжээ нь банк бус санхүүгийн байгууллагын хэрэглээний зээлийн эрэлтэд нөлөөлж, тус бодлогын үр нөлөөг бууруулах эрсдэл үүсгэжээ. Тодруулбал, 2022 оны эцсийн байдлаар банк бус санхүүгийн байгууллагын нийт хэрэглээний зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 33.3 хувиар буюу 367.0 тэрбум төгрөгөөр өсөж 1.5 их наяд төгрөгт хүрсэн байна.

Иймд банкнаас олгох иргэдийн хэрэглээний зээлд тавигдаж буй дээрх хязгаарлалтын арга хэмжээг банк бус санхүүгийн салбарт давхар мөрдүүлэх нь өрхийн өрийн дарамтыг бууруулах, мөн банк санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангахад чухал ач холбогдолтой юм.

ДӨРӨВ.ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Монголбанкны санхүүгийн тайлан, түүнд холбогдох аудитын санал, дүгнэлт болон Хяналтын зөвлөлийн санал, зөвлөмжийн хэрэгжилтэд шинжилгээ хийж дараах дүгнэлтийг хүргүүлж байна. Үүнд:

1. Монголбанк нь ашгийн бус байгууллага бөгөөд үйл ажиллагааны санхүүгийн үр дүн болон хөрөнгө, өр төлбөр, өөрийн хөрөнгийн бүтэц нь Монгол банкны үйл ажиллагаагаар тодорхойлогддог. Монголбанкны 2022 оны жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайлангаас авч үзвэл 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт хөрөнгө 21,204,652 сая төгрөг, нийт өр төлбөр 26,334,764 сая төгрөг, өөрийн хөрөнгийн хэмжээ (5,130,112) сая төгрөг, хуримтлагдсан алдагдал (7,087,754) сая төгрөг байгаа бөгөөд тайлант хугацаанд **1,758,056** сая төгрөгийн алдагдалтай ажиллажээ;
2. 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн 8 зөвлөмжөөс 2022 онд бүрэн хэрэгжүүлсэн 3 зөвлөмж, хэрэгжих шатанд байгаа 4 зөвлөмж, хэрэгжээгүй 1 зөвлөмж байна гэж Хяналтын зөвлөл дүгнэсэн байна;
3. Хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны тайлан болон Хяналтын зөвлөлөөс Монголбанканд хүргүүлсэн санал, зөвлөмжийн агуулга, түүний хэрэгжилтийн байдлыг хянан үзэхэд Хяналтын зөвлөл нь хуульд заасан чиг үүргээ хараат бусаар хэрэгжүүлж ажилласан байна;
4. Хяналтын зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр дуусгавар болж байгаатай холбогдуулан Хяналтын зөвлөлийн тогтоол, албан бичиг, хурлын тэмдэглэлээр 2017-2021 онд Монголбанканд хүргүүлсэн нийт 50 санал, зөвлөмжийн хэрэгжилтийг 2022 оны жилийн эцсийн байдлаар хянан үзэхэд, нийт санал, зөвлөмжийн хэрэгжилтийн дундаж 85.4 хувьтай байна;

Дээрх дүгнэлтийн хүрээнд дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. Хөндлөнгийн аудитаас өгсөн *“Монголбанкны мэдээллийн технологийн систем дэх мэдээллийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, кибер аюулгүй байдлыг хангах”* талаарх зөвлөмж болон бусад зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллахад анхаарах;
2. Хяналтын зөвлөлөөс 2017-2021 онд Монголбанканд хүрүүлсэн нийт санал, зөвлөмжөөс хэрэгжилт хангалтгүй 7 санал, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллахад анхаарах. Тухайлбал, Монголбанкны үйл ажиллагааны алдагдлыг бууруулах талаарх Хяналтын зөвлөлийн санал, зөвлөмж;
3. Улсын Их Хурлын 2003 оны 39 дүгээр тогтоолоор баталсан “Монголбанкны Хяналтын зөвлөлийн ажиллах журам”-ын 2.1-д заасан зарим чиг үүргийн хэрэгжилтийг үр дүнтэй хэрэгжүүлэх зохицуулалтыг тодорхой болгох. Үүнд:
 - 2.1.4-т заасан *“Монголбанкны Зөвлөлийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавих”*;
 - 2.1.6-д заасан *“дотоод хяналтын талаар гаргасан журам, дотоод хяналтын үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөө, тэдгээрийн хэрэгжилтийн байдалтай танилцаж, холбогдох арга хэмжээ авахыг Монголбанкны удирдлагад санал болгох”*;
 - 2.1.7-д заасан *“хөрөнгө оруулалтын багцад хяналт тавих”*.

---000---